

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНЭЭР ТОМИЛУУЛАХ НЭР  
ДЭВШИГЧДИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Ш.Түвдэндорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах нэр дэвшигчдийн тухай асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Шарын Цогтоо, Дамдинсүрэнгийн Солонго нарын нэрийг дэвшүүлэхээр санал болгосон.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Шарын Цогтоо нь 1954 онд Сүхбаатар аймгийн Халзан суманд төрсөн. Хуульч, эрх зүйч мэргэжилтэй.

Нэр дэвшигч Ш.Цогтоо нь хууль, эрх зүйн өндөр мэргэшилтэй, мэдлэг боловсрол, ажлын туршлагаараа Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байна.

Мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Дамдинсүрэнгийн Солонго нь 1958 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрх зүйч мэргэжилтэй.

Нэр дэвшигч Д.Солонго нь хууль, эрх зүйн өндөр мэргэшилтэй, мэдлэг боловсрол, ажлын туршлагаараа Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хороо дээрх асуудлыг хэлэлцээд Ш.Цогтоо, Д.Солонго нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох болон бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Банзрагчийн Пүрэвням, Цэрэнбалтавын Сарантуяа нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын дээд шүүхээс санал болгосон нэр дэвшигчдийн тухай асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ